

**ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖИЙН
ХИЛИЙН ЦЭСИЙН ЗУРГИЙГ ХАДГАЛАХ, АШИГЛАХ,
ӨӨРЧЛӨЛТИЙГ ТУСГАХ ЖУРАМ**

Нэг.Ерөнхий зүйл

1.1.Энэхүү журмын зорилго нь Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэс /цаашид “хилийн цэс” гэх/-ийн зургийг хадгалах, ашиглах, тэдгээрт орсон өөрчлөлтийг тусгах харилцааг зохицуулахад оршино.

1.2.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, орон нутгийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага (цаашид “аймаг, нийслэл, дүүргийн Газрын алба” гэх), сумдын газрын даамлууд энэхүү журмыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллана.

1.3.Хилийн цэсийг тогтоосон үндсэн бичиг баримтад Аж ахуй хоорондын газар зохион байгуулалтын материалууд, калькан зураг, боть ном болон Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн цахим систем (цаашид “Цахим систем” гэх) дэх бүртгэл, хилийн цэстэй холбоотой эрх бүхий байгууллагын шийдвэр зэрэг иж бүрдэл байна.

1.4.Хилийн цэсийн зургийн үндсэн баталгаа нь хуулийн дагуу хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоол байх бөгөөд үнэн зөв зурагдсан эсэхийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага хариуцна.

1.5.Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоол, шийдвэрийн дагуу эрх бүхий байгууллагаас боловсруулсан хилийн цэсийн зураг, хилийн цэсийн цахим систем дэх тоон мэдээлэл нь тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн албан ёсны хил хязгаарыг илэрхийлэх үндсэн баримт бичиг болно.

1.6.Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийг эрхлэх, хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хилийн цэсийн мэдээллээр орон нутгийн удирдлага, иргэд, олон нийтийг хангах зорилгоор цахим системийг ашиглана.

1.7.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага нь цахим системийг эрхлэх бөгөөд аймаг, нийслэл, дүүргийн Газрын алба, сумдын даамлуудыг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

Хоёр.Хилийн цэсийн зургийн өөрчлөлтийг бүртгэх

2.1.Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн эргэлтийн цэг, шугамыг дараах тохиолдолд өөрчлөн бүртгэнэ.

2.1.1.Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 13.1, 14.1-д заасан тохиолдолд;

2.1.2.Хилийн цэсийн эргэлтийн цэг, шугам нь хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, эсхүл Улсын Их Хурлын тогтоол, тэдгээрийн холбогдох хавсралт, хилийн цэсийг тогтоох үед ашигласан том, жижиг масштабын зураг, газар зүйн нэрийн зураг зэрэг архивын баримт, материалаас зөрүүтэй зураглагдсан, цахим системд бүртгэгдсэн нь нотлогдсон;

2.2.Хилийн цэсэд өөрчлөлт оруулах, тодотгох асуудлыг Засгийн газрын 2024 оны 92 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Газар зохион байгуулалт хийх журам”-ын 6 дугаар зүйлд заасны дагуу шийдвэрлэнэ.

2.3.Хилийн цэсэд өөрчлөлт оруулах шийдвэрийг үндэслэн Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага шинэчлэн цахим систем 30 хоногийн дотор бүртгэж, өөрчлөх шийдвэр, ажлын хэсгийн дүгнэлт, зураг болон бусад холбогдох материалыг хавсралтаар оруулна.

2.4.Өөрчлөлт орж хүчингүй болсон хилийн цэсийн эргэлтийн цэг, шугамын мэдээллийг түүхчилсэн байдлаар цахим системд бүртгэж, газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын архивд хэвлэмэл хэлбэрээр хадгаламжийн нэгж үүсгэж хадгалуулна.

2.5.Энэ журмын 2.4-т заасан хилийн цэсийн түүхчилсэн өөрчлөлтийн хэвлэмэл хэлбэрээр зураглаж архивт хүлээлгэн өгөхдөө Засгийн газрын 2024 оны 92 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Газар зохион байгуулалт хийх журам”-ын 6.10-т заасан шаардлагыг хангасан байх бөгөөд холбогдох албан тушаалтнууд гарын үсэг зурж баталгаажуулсан байна.

2.6.Энэ журмын 2.5-д заасан зурагт засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тогтоосон эргэлтийн цэгийн нэр, тоот өндөрлөгүүдийг газар зүйн солбилцол, нутаг дэвсгэрийн талбайн хэмжээ, түүнд орсон өөрчлөлтийг тусгасан байна.

2.7.Хилийн цэсийн эргэлтийн цэг, шугам, маргааны бүртгэл зэргийг цахим системд иргэд олон нийтэд нээлттэй байдлаар бүртгэнэ.

Гурав.Хилийн цэсийн зургийг ашиглах

3.1.Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн зарлиг, Улсын Их Хурлын тогтоолын дагуу хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа болон өөрчлөлт орж шинэчлэгдсэн хилийн цэсийг цахим системээр дамжуулан төрийн байгууллага, иргэн, хуулийн этгээд ашиглана.

3.2.Цахим систем нь иргэд, олон нийтэд нээлттэй байх бөгөөд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн эргэлтийн цэг, шугамын тоон мэдээллийг ашиглаж болно.

3.3.Цахим системийн төрийн болон албаны нууцад хамаарахаас бусад мэдээлэл нь иргэд, олон нийтэд нээлттэй байна.

3.4.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэл, дүүргийн Газрын алба, сумдын газрын даамал нь иргэд, олон нийтийг үнэн зөв, бодит мэдээллээр цаг тухай бүр хангаж ажиллана.

3.5.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага болон аймаг, нийслэл, дүүргийн Газрын алба, сумын газрын даамал нь хээрийн хэмжилт тодруулалтын ажилд болон маргаан шийдвэрлэх зорилгоор хилийн цэсийн цаасан зургийг бэлтгэж үйл ажиллагаандаа ашиглаж болно.

3.6.Иргэд, олон нийт нь Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын төрийн архивд хадгалагдаж буй хилийн цэсийг тогтоосонтой холбоотой цаасан болон калькан зураг, боть ном зэрэг архивын баримт материалыг Архивын ерөнхий газрын даргын 2023 оны 68 дугаар тушаалын дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан “Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн баримтын архиваас үзүүлэх үйлчилгээний хөлсний хэмжээ”-д заасан үйлчилгээний хөлсийг төлж ашиглаж болно.

Дөрөв.Хилийн цэсийн зургийг хадгалах

4.1.Аймаг, нийслэл, сум, дүүргийн хилийн цэсийн зургийг Газрын тухай хуулийн 8.3 дугаар зүйлд заасны дагуу тухайн шатны засаг дарга хадгалах бөгөөд

улсын хэмжээний иж бүрэн хувийг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын архивд хадгална.

4.2.Хилийн цэсийн зургийг хадгалахад Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2021 оны 222 дугаар тушаалаар батлагдсан “Байгууллагын архивын үйл ажиллагааны нийтлэг журам”, 2025 оны 222 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн архивын үйл ажиллагааны нийтлэг журам”-ыг тус тус мөрдөж ажиллана.

4.3.Улсын Их Хурлын тогтоолоор шинэчлэн баталж буй засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн зураг мэдээллийг Засгийн газрын 2024 оны 91 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Газар зохион байгуулалт хийх журам”-ын 6 дугаар зүйлийн 6.10-т заасны дагуу зураглан газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын архивд хадгална.

4.4.Өөрчлөлт орж хүчингүй болсон хилийн цэсийн эргэлтийн цэг, шугамын тоон болон зурган мэдээллийг “Хилийн цэсийн цахим систем”-д түүхчилсэн байдлаар хадгална.

Тав.Бусад

5.1.Улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн мэдээллийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар хянаж, шалгах ажлыг гүйцэтгэж болно.

5.2.Хилийн цэсийн мэдээллийг хянаж, шалгах ажлыг газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын даргын тушаалаар батлагдсан удирдамжийн дагуу гүйцэтгэнэ.

5.3.Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн Газрын алба, сумдын даамлууд нь иргэд, олон нийтийг “Хилийн цэсийн цахим систем”-ээс зөрүүтэй мэдээллээр хангаж, хилийн цэсийн бодит бус маргаан үүсгэхийг хориглоно.

5.4.Энэхүү журмыг зөрчсөн албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль болон бусад холбогдох хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.